



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1104

Амардалай

Иргэдийн оролцоотой бүтээн байгуулалтын
жил болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 01 сарын 05-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлгэрцогт сум байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтан сум орон нутгийн өнгө үзэмжийг сайжруулан ая тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор 2022 оныг “Иргэдийн оролцоотой бүтээн байгуулалтын жил” болгон зарласугай.

Хоёр. “Иргэдийн оролцоотой бүтээн байгуулалтын жил”-ийн төлөвлөгөөг батлуулж удирдлага зохион байгуулалтаар ханган, үе шаттайгаар аян зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээллэж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Золжаргал)-д үүрэг болгосугай.

Гурав. Хоггүй цэвэр, өнгө үзэмжтэй, тохилог орчныг бий болгоход олон нийтийг уриалж, манлайлан ажиллахыг багийн Засаг дарга нар, ААНБайгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Идэвхи санаачлагатай оролцсон ААНБайгууллага, айл өрх, иргэдийг шагнаж, урамшуулахад шаардагдах санхүүжилтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулахыг Засаг даргын тамгын газрын дарга (С.Нарантунгалаг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

4880200462